

ОРОС УЛСААС МОНГОЛЫН НИСЭХ ХҮЧНИЙ САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХЭД ҮЗҮҮЛСЭН ТУСЛАМЖИЙН ТУХАЙД (1925-2021)

Н.ХҮДЭРБАТ

*Докторант, дэд хурандаа
БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын төвийн
эрдэм шинжилгээний ажилтан*

Ц.БЯМБА-ЭРДЭНЭ

*Докторант, ахлах дэслэгч
БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын төвийн
эрдэм шинжилгээний ажилтан*

1921 оноос Монгол Улсын цэргийн зохион байгуулалтыг Европ хэв маягийн зохион байгуулалтанд шилжүүлэх үйл явц өрнөж, аажмаар төрөл мэргэжлийн ангиудыг байгуулж шинэ төрлийн зэвсэглэл, техникээр хангаж үйл явц эхэлсэн.

Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ)-ын Засгийн газартай урьдчилан тохиролцсон гэрээ хэлэлцээрийн үр дүнд 1925 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Нийслэл хүрээний Консулын дэнж буюу одоогийн Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “**Монгол ард**” хөшөө байрлаж байгаа газар Монголын нисэх эскадрилийн нисэх хүчний анхны онгоц болох тээврийн зориулалттай Ю-13 хэмээх нисэх онгоцыг Зөвлөлтийн нисгэгч А.А.Лапин даргатай нисэх баг буулгасан бөгөөд тэднийг маршал Х.Чойбалсан тэргүүтэй Цэргийн яамны удирдах хүмүүс угтан авсан¹ нь Монгол Улсад нисэх хүчний салбар хөгжих анхны шанг татсан үйл явдал болсон юм.

Монголын нисэх хүчний хөгжлийн I үе шат (1925-1945)

Тухайн үед Монголын нисэх хүчинд боловсон хүчний асуудал шийдэгдээгүй байсан учир шуудан тээврийн нислэгийг ЗОУ-аас ирсэн нисэх багийн хамт олон гүйцэтгэж байсан учир төр засгаас цаашид нисэх хүчний анги, салбарыг байгуулах боловсон хүчнийг бэлтгэх, нисэх хүчний ач холбогдолыг ард олонд сурталчлах асуудлуудыг шат дараатайгаар авч хэрэгжүүлж, боловсон хүчнийг бэлтгэх, асуудлыг ЗОУ (ЗХУ)-тай хамтран шийдвэрлэсэн юм.

Монголын агаарын замыг 1926 онд анх нээсэн ба тээврийн нисэх отрядыг 1936 онд байгуулж, цэргийн болон иргэний зориулалттай нислэгийн үүрэг гүйцэтгэж

¹ “Монголын нисэх хүчний үе үеийн мэргэжлийн боловсон хүчин” УБ., 2002. т.7

эхэлсэн түүхтэй. Дайны дараах бүтээн байгуулалтын ажил эхлэх үед нисэхийн 5 дугаар холимог хороо иргэний агаарын тээврийн үүрэг гүйцэтгэж байжээ. Өгүүлэн буй үеүүдэд цэргийн нисэх хүчний удирдлагад Зөвлөлт Холбоот улсаас зөвлөх, сургагч, мэргэжилтнүүд олон тоогоор ажиллаж байсан түүхтэй. Нисэх хүчний салбар нь эмнэлэг, харилцаа холбоо, агаарын тээврийн үйлчилгээнд нислэг зохион байгуулж, улмаар алслагдсан аймгуудын чиглэлд зорчигч тээврийн албанд² хүчин зүтгэх болсон юм.

Монголын цэргийн нисэх хүчин удирдлага 1937 оноос Нисэх хүчин, 1938 оноос Бүх цэргийн агаарын хүчин, 1942 оноос Монгол Ардын Хувьсгалт Цэргийн (МАХЦ)-ийн нисэх хүчин хэмээн нэрлэгдэж байсан бол нисэх хүчний салбар нь жанжин Д.Сүхбаатрын нэрэмжит Нисэх онгоцны отряд, Нисэх бригад (1933.10.14-1934.01.27), Агаарын хүчний хэрэг эрхлэх газар (1937.08.30), Довтлон дайрагч хөнгөн онгоцны 1 дүгээр хороо (1938.06.30) Баянтүмэнд, Бөмбөгдөгч 2 дугаар хороо (1938.06.30) Сонгинод, Нисэх дивиз (1942.11.25-1945.12.07) 13 төрлийн олон тооны нисэх онгоцтой байв. **(Зураг 1)**

Халх голын дайнд нисэх хүчний салбарууд Ламын сүм, Халуун рашааны өртөө, Жинжийн сүм, Хайлаарын районы аэродромуудад бөөгнөрсөн дайсны цэргийн бүлэглэлийг нийт 15 удаа бөмбөгдөж ихээхэн хэмжээний хохирол³ учруулснаас гадна Өвөр Монголын ард түмнийг Чөлөөлөх дайнд агаарын цэргийн анги, салбаруудаас 5 онгоцтой нисэх хэсэг байлдааны ажиллагаанд оролцож Цагааннуураас Хятадын Долнуурын чиглэлд давшиж явсан өөрийн ангиудад дээд командлалын мэдээ, холбоог дамжуулах, Долнуураас Хаалган хүртэл агаараас тагнах нислэг, дайны талбарт шархадсан өвчилсөн цэргийн алба хаагчдыг татан гаргах үүргүүдийг (52 удаа) гүйцэтгэсэн бол 1947 онд Байтаг Богд уулын районд болсон байлдааны ажиллагаанд нисэх хүчний дарга бөгөөд хэлтсийн дарга хошууч генерал М.Зайсанов, нисэх отрядын дарга Д.Гунгаа (*Монгол улсын баатар 2009.08.24*) нараар ахлуулсан 8 нисэх онгоц оролцож, газрын цэрэгтэй харилцан ажиллаж байсан түүхтэй.



2 “Монголын үндэсний агаарын тээвэрлэгч (үүсэл, хөгжил, ирээдүй)” УБ., 2015. т.25

3 “Талын Бүргэд” УБ., 2018 т.97

Монголын нисэх хүчний хөгжлийн II үе шат (1946-1977)

Цэргийн нисэх хүчний удирдлага 1945 оноос Агаарын хүчний хэлтэс, МАХЦ-ийн явдлын яамны агаарын хүчний хэрэг эрхлэх хэлтэс, 1951 оноос МАХЦ-ийн нисэх хүчний газар, 1952 оноос Нисэх хүчний хэлтэс, 1977 оноос Ардын армийн жанжин штабын нисэхийн алба, 1979 оноос Батлан хамгаалах яамны нисэхийн хэлтэс, Монголын нисэх хүчний нэршил, Нисэх холимог 5 дугаар хороо (1945.12.07-1957.02.18), Улаан тугийн одонт нисэх 5 дугаар отряд гэх нэршилтэй байв. 1960-аад оны дунд 1980-аад оны эхэн үед Монголын ардын армийг өргөтгөн зохион байгуулах цэргийн анги, нэгтгэлүүдэд шаардлагатай зэвсэг, байлдааны техникийг БНМАУ ба ЗСБНХУ-ын Засгийн газар хооронд 1964-1976 онд байгуулсан удаа дараагийн хэлэлцээрээр ЗХУ-аас хангасан юм. *(Зураг 2)*

Сөнөөгч болон байлдааны нисдэг тэрэгний анги, салбарууд нь Монгол-Зөвлөлтийн хамтарсан байлдааны буудлагатай хээрийн сургууль, анги, салбаруудын хамтарсан сургалтад оролцож, дадлагажин нисгэгч нарын байлдааны сургалт бэлтгэл, мэргэжлийн ур чадвар дээшилж байсан. **Тухайлбал:** Монгол-Зөвлөлтийн цэргийн анги, салбаруудын хамтарсан “Хэрлэн-73” (Миг-17пф), (УТИ Миг-15) “Говь-77”, “Найрамдал-79” (Миг-21 ум), (Миг-21 пфм) хээрийн сургууль, Ардын хувьсгалын 50, 70 жилийн ойн баярын ёслолын арга хэмжээнд дээрх сөнөөгч онгоцууд оролцож байжээ.



Монголын нисэх хүчний хөгжлийн III үе шат (1980-2021)

Цэргийн нисэх хүчний удирдлага 1945 оноос Агаарын хүчний хэлтэс, МАХЦ-ийн явдлын яамны агаарын хүчний хэрэг эрхлэх хэлтэс, 1951 оноос МАХЦ-ийн нисэх хүчний газар, 1952 оноос Нисэх хүчний хэлтэс, 1977 оноос Ардын армийн жанжин штабын нисэхийн алба, 1979 оноос Батлан хамгаалах яамны нисэхийн хэлтэс, 1984 оноос Монголын ардын армийн авиацийг удирдах газар, 1989 оноос

Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэрэг-нисэх хүчний командлал нэртэй болж үйл ажиллагаагаа явуулж байв.

1990-ээд оны эхээс цэргийн нисэх хүчний бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанд ихээхэн өөрчлөлт орж, бие даан үйл ажиллагаагаа явуулах болов. 1991 оны 5 дугаар сарын 15-нд цэргийн нисэхийн 4 тусгай ангийг нэгтгэж Ардын цэргийн 1 дүгээр нисэх тусгай хороо болгон зохион байгуулагдсан.

1. 2007 оноос Зэвсэгт хүчний Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлал-нисэхийн хэлтэс
2. 2016 оноос Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал нэртэй болж үйл ажиллагаагаа явуулж байна.

Агаарын цэргийн командлалын харьяа Зэвсэгт хүчний **303** дугаар анги, **337** дугаар ангиуд шинээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Тус ангиуд Монгол Улсын агаарын орон зай, агаарын хилээ хамгаалах, манай улсын дээгүүр дамжин өнгөрч буй онгоцнуудад агаарын сахилга бат сахиулах, шаардлагатай бол устгах, албадан буулт хийлгэх зэрэг үүрэгтэйгээс гадна цэргийн дээд командлалаас ирсэн тусгай үүргийн нислэгийн үүрэг гүйцэтгэж байна.

1996 оноос эхлэн ОБЕГ, ИНЕГ хамтарсан сургалтууд, 1999 онд АНУ-ын цэргийн алба хаагчидтай хамтарсан “Баланс мэжик”, 2000 онд Олон улсын энхийг сахиулах “ЦентрАзБат-2000” хээрийн сургууль, Монгол-Оросын зэвсэгт хүчний хамтарсан “Дархан”, “Сэлэнгэ -2012⁴, 2013, 2014, 2019, 2021” хээрийн сургууль, Ази Номхон далайн бүсийн улс орнуудын хамтарсан “Хааны эрэл -2012” энхийг дэмжих ажиллагааны сургуулиудад агаарын цэргийн анги, салбарын цэргийн алба хаагчид оролцож үүрэг гүйцэтгэсэн. (Зураг 3)

ОХУ-аас Монгол Улсын нисэх хүчний салбарт тусламжаар өгсөн зарим төрлийн онгоцыг багцаа үнээр нэгтгэн үзүүлбэл:

№	Онгоцны марк	Үйлдвэрлэгдсэн огноо	Тоо ширхэг (нэгж)	Нэг бүрийн үнэ (рубль, доллар)	Нийт үнэ (рубль, доллар)	Одоогийн хаш (төгрөг)
1	Ан-24 (Ан-14)	1974	2	19 000 000 рубль	38 000 000	1 468 320 000
2	Ан-26 (Ан-24)	1981	4	385 000 доллар	1 540 000	5 926 998 000
3	Ми-171 Е	2007	2	8 009 000 доллар	16 018 000	45 630 476 600
4	Ми-26 Т (Ми-24В)	1991	8	28 000 000 рубль	224 000 000	8 655 360 000
5	Ми-8 Т	1987	5	70 000 000 рубль	350 000 000	13 524 000 000
6	МиГ-29		2	25 000 000 доллар	50 000 000	142 400 000 000
7	Нийт үнэ				217 605 154 000 төгрөг	

4 Даваасамбу.Я Эрдэнэбат.Б Очирбат.Н “Монгол улсын цэргийн нисэх хүчин” УБ., 2015 т.216

Дүгнэлт

Монгол Улсын бүх аймаг, сум руу очих агаарын замыг Зөвлөлтийн нисгэгч нар анхлан нээснээс гадна Монголын нисэх хүчний ууган нисгэгч нарыг бэлтгэн гаргаснаас гадна нисэх хүчний салбарын тогтолцоог боловсронгуй болгоход үнэтэй хувь нэмэр оруулсан түүхтэй.

Эх орноо харийн түрэмгийллээс хамгаалах хэрэгт ЗОУ, Монголын агаарын цэргийн нисгэгчид мөр зэрэгцэн фронтын тэргүүн эгнээнд явж, алдар гавьяа байгуулсан цэргийн алдартнуудын дундаас Монгол Улсын баатар цолтон төрөн гарчээ. Нисэх хүчний салбар ард түмнийхээ нийгмийн хамгаалал, улс ардын аж ахуй соёлыг хөгжүүлэхэд үйлсэд үлэмж хувь нэмрийг оруулж ирсэн.

Цаашид нисэх хүчний салбарт хамтын гэрээгээр олгосон зэвсэглэл, техникийн тооцоог нарийн нягтлан судлан үзэх шаардлага зүй ёсоор урган гарч байна. Түүхэн уламжлалт харилцаатай ОХУ-тай хамтран ажиллах Монголын зэвсэгт хүчний түүхэн хөгжлийн үе эргэн эрчимтэй сэргэж байгаа өнөө үед зэвсэгт хүчний төрөл мэргэжлийн анги, салбаруудыг ойрын ирээдүйд шинэ төрлийн зэвсэглэл, техникээр хурдацтай хангах бүрэн боломж нээгдэж байна.

Ном зүй

1. Батмөнх.С “Манай нисэхийн анхны дарга БНМАУ-ын баатар Б.Цог” УБ., 2012
2. Гомбосүрэн.Д “Монгол улсын зэвсэгт хүчний байгуулалтын түүх” УБ., 2009
3. Даваасамбуу.Я Эрдэнэбат.Б Очирбат.Н “Монгол улсын цэргийн нисэх хүчин” УБ., 2015
4. Дашбалбар.М “Тэнгэр заяатай хүмүүс” УБ., 2007
5. Отгонжаргал.Д “Тэнгэрийн хотын од” УБ., 2015
6. Тогоондорж.Ч Даваасамбуу.Я “Цэргийн нисэх эскадриль” УБ., 2013
7. Шагдаржав.М “Монгол ардын хувьсгалт цэргийн агаарын нисэх хүчний 10 жилийн ой” УБ., 2020
8. Шагдаржав.М “Армийн нисэх хүчний анги, нэгтгэлүүдийн түүх” УБ., 2020
9. “Монголын нисэх хүчний үе үеийн мэргэжлийн боловсон хүчин” УБ., 2002
10. “Монголын үндэсний агаарын тээвэрлэгч (үүсэл, хөгжил, ирээдүй)” УБ., 2015
11. “Талын Бүргэд” УБ., 2018

Зураг 1



Ан-24 тээврийн онгоц



Ан-26 ачаа тээврийн онгоц



Ми-171 Е нисдэг тэрэг



Ми-24В байлдааны нисдэг тэрэг



МиГ-29 сөнөөгч онгоц

Зураг 2



Ю-13 тээврийн онгоц



У-1 сургуулийн онгоц



Р-5 сөнөөгч онгоц



Р-1 хөнгөн бөмбөгдөгч тагнуулын онгоц



Ю-33 тээврийн онгоц



У-2 (По-2) олон зориулттай онгоц



К-5 ачааны зориулалттай н онгоц



Сталь-3 тээврийн онгоц



И-15 бис сөнөөгч онгоц



С-2 эмнэлгийн зориулалттай онгоц



Я-6 (АИР-6) тээврийн онгоц



Ил-2 дайрагч онгоц

Зураг 3



Ан-2 тээврийн онгоц



Ан-14 тээврийн онгоц



МиГ-15 УТИ сургалтын зориулалттай байлдааны онгоц



МиГ-17 байлдааны онгоц



МиГ-21 УМ байлдааны онгоц



МиГ-21 ПФМ байлдааны онгоц